БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 13 өдөр Дугаар А/296 Улаанбаатар хот

1 дүгээр хорооны нийтийн эзэмшлийн 16, 18, 22, 23 дугаар байрны ариутгах татуургын хэвтээ шугам шинэчлэх материал худалдан авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, Засгийн газрын 2021 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн "Журам батлах тухай" 160 дугаар тогтоол, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн ээлжит XXVI хуралдааны 16 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтад заагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалт"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах нийтийн эзэмшлийн орон сууцны 16, 18, 22, 23 дугаар байрны ариутгах татуургын хэвтээ шугам шинэчлэхэд шаардагдах материал худалдан авах ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Дэмчигжав
(Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга)

Гишүүд: Б.Мөнхчимэг
(Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн Хот байгуулалт, барилга, орон сууц хариуцсан мэргэжилтэн)
Л.Ариунжаргал
(Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн Төлөвлөлт, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн)
Т.Цогжавхлан
(Багануур-Ус ААТҮГ-ын Орон сууцны инженер)

Нарийн бичгийн дарга: Г.Туул
(Нийлүүлэгч "БЦНТ" ХХК-ийн гүйцэтгэх захирал)

2.Ажлын хэсэгт ажиллахаас өмнө ашиг сонирхлын зөрчилтэй эсэх талаар мэдэгдэл, тайлбар гаргахыг Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

D:\2023\Zahiramj\Zahiramj.docx

1202010709

3.Батлагдсан техникийн тодорхойлолтын дагуу холбогдох хууль журамд нийцүүлэн, тухайн бараа материалын бүрэн бүтэн байдал, чанарын баталгаа, иж бүрдэл зэргийг бүрэн хэмжээгээр шалгаж хүлээн авахыг Ажлын хэсэг (Д.Дэмчигжав)-т, хөрөнгийг өмчид бүртгүүлэн ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Н.Оюунцэцэг)-т тус тус даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Балжинням)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА С.ДАВААСҮРЭН